

ДОТООДЫН

ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО
ХОНОГИЙН ТОЙМ



Дотоодын зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- MSE:SUU хувьцаа 18 орчим хувиар өслөө
- Дотоодын компаниудын харьцаа үзүүлэлтүүд буурч хувьцааны ханш өсөх хандлагатай байна.
- Банкны салбарын P/E харьцаа ТОП-20 индексийн дунджаас 2 дахин бага байна.

МХБ-ийн индексийн өгөөж

Индекс	Долоо хоног	Сар	Жил
ТОП 20	0.52%	1.35%	25.47%
MSE A	-0.37%	0.05%	20.27%
MSE B	-1.35%	-0.07%	34.89%
2025/06/23 – 2025/06/27			

Идэвхтэй арилжаалагдсан үнэт цаас

Симбол	Үнийн дүн
MNDL	4,808,162,935.62
MFG	1,024,112,186.41
MGLA	682,917,895.16
KHAN	403,962,003.00
INV	300,085,890.00
2025/06/23 – 2025/06/27	

Өндөр өсөлттэй үнэт цаас

Симбол	Хаалтын ханш	Өсөлт %
SUU	682.56	17.89%
SEND	148.99	16.85%
MDZ	7,935.00	15.00%
CNF	58,900.00	14.81%
MNDL	81.89	12.89%
2025/06/23 – 2025/06/27		

2025 он 06-р сарын 30

Зах зээлийн
үнэлгээ тэрбум ₮

12,015

ТОП-20 индекс

48,859

MSE A

17,569

MSE B

14,233



МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ДНБ өсөлт

2.4%

2024 - I улирал

Инфляц

8.3%

2025-05 сар

ГВУН(сая\$)

5,193.73

2025-05 сар

Бодлогын

хүү

12.0%

ЗГ-ын бондын
өгөөж

6.6%

USD/MNT

3,580.71

2025-06-29



Эдийн засгийн мэдээлэл

ХАРЬЦАА ҮЗҮҮЛЭЛТҮҮД БУУРЧ ХУВЬЦААНЫ ХАНШ ӨСӨХ ХАНДЛАГАТАЙ БАЙНА



Зураг 1. ТОП-20 индекст багтах компаниудын P/E (2025.06.24)



P/E буюу үнэ-ашгийн харьцаа бол хувьцаа хэр үнэтэй байгаа эсэхийг дүгнэх суурь үзүүлэлт бөгөөд ирээдүйн ханшийн чиг хандлагыг тодорхойлох хэрэгслүүдийн нэг. Тэгвэл уг харьцаа бага байх тусам хувьцааны үнэ хямд байгааг илэрхийлдэг.

ТОП-20 индексийн үнэ-ашгийн харьцааны дундаж 5.51 байгаа бөгөөд ихэнх компаниуд бодит үнэлгээнээс доогуур үнэлэгдсэн байна.

Дунджаас доогуур харьцаа үзүүлэлттэй байгаа компаниудын хувьцааны ханш сүүлийн хагас жилд өсөх боломж өндөртэй гэсэн үг. Мөн 2024 оны байдлаар ТОП-20 индексийн дундаж P/E харьцаа 8.4 байсан бол өнөөдөр 5.51 болтлоо буурчээ.

*Банкны салбарын P/E=3.42, Банкнаас бусад салбарын дундаж P/E=6.38

Тэгвэл банкнуудын хувьцааны харьцаа үзүүлэлт банкнаас бусад салбаруудын дундаж үзүүлэлтээс 2 дахин бага байгаа учир цаашид банкнуудын хувьцаа өсөх боломж хэвээр байсаар байна.


Хүснэгт 1. Эдийн засгийн голлох үзүүлэлтүүдийн хүлээлт

Үзүүлэлт	2025 оны II улирал	2026 оны I улирал
Инфляц	9.8%	10.0%
Эдийн засгийн өсөлт	4.0%	4.6%
Бодлогын хүү	12.0%	11.6%
Зээлийн хүү	17.2%	17.3%



Зах зээлийн мэдээлэл

СҮҮ ХК-НИЙ ХУВЬЦААНЫ ХАНШ 18 ХУВИАР ӨСЛӨӨ



Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй Сүү ХК [MSE:SUU]-ийн хувьцаа 2025 оны 6-р сарын 26-ны арилжаагаар 682.56₮-т хаагдаж, сүүлийн гурван сарын хамгийн өндөр ханшдаа хүрлээ. Энэ нь зөвхөн ханшийн хэлбэлзэл бус, компанийн санхүү, үйл ажиллагааны үр дүнг илэрхийлж буй эерэг дохио гэж хөрөнгө оруулагчид үнэлж байна. 2025 оны эхний хагаст Сүү ХК-ийн хувьцааны ханш 30 гаруй хувиар өссөн нь үндэсний хүнсний томоохон үйлдвэрлэгчийн хувьд зах зээлийн дэмжлэг, хөрөнгө оруулагчдын итгэлийг бодитоор илэрхийлж байна.

Хувьцааны ханш тогтмол өсөхийн зэрэгцээ бодит ногдол ашиг тараах нь компанийн үйл ажиллагаа, ашгийн чанар, удирдлагын бодлого нь зах зээлийн шаардлагад нийцэж буйг харуулж байна. Хүнсний салбарын тогтвортой өсөлт, хэрэглэгчдийн итгэл, менежментийн тууштай байдал нь Сүү ХК-ийг тогтвортой өгөөжтэй хөрөнгө оруулалтын нэгэн хувилбар болгон харуулж байна.

МАНДАЛ ДААТГАЛ ХК ХУВЬЦААНЫХАА 5 ХУВИЙГ ХАЛААСАЛЛАА

2025 оны 6-р сарын 27-нд “Мандал даатгал” ХК нийт 31.2 сая ширхэг хувьцаа буюу компанийн нийт хувьцааны 5 хувийг эргүүлэн худалдан авсан талаарх мэдэгдэл гаргалаа. Энэ нь тус компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 6-р сарын 9-ний өдрийн шийдвэрийн дагуу хэрэгжсэн томоохон санхүүгийн алхам юм.

Худалдан авалтын гол үзүүлэлтүүд:

- Хугацаа: 2025 оны 6-р сарын 16–27-ны хооронд
- Ханшийн хүрээ: 71.00₮ – 84.52₮
- Хувьцааны тоо: 31,215,080 ширхэг
- Худалдан авалтын зорилго: Нэгж хувьцаанд ногдох ашгийг нэмэгдүүлэх, хувьцааны ханшийн тогтвортой байдлыг хангах


Компанийн зүгээс уг худалдан авалтыг зах зээлийн дундаж ханшийн орчимд хийж, арилжаанд оролцож буй хямд үнийн саналд хариу өгөх байдлаар хэрэгжүүлсэн байна. Ингэснээр эргэлтэд байгаа энгийн хувьцааны тоо буурч, нэгж хувьцаанд ногдох ашиг нэмэгдэх замаар компанийн үнэлгээ, хөрөнгө оруулагчдын итгэлд эерэг нөлөө үзүүлэх зорилготой байжээ.

ДОТООДЫН ХУВЬЦААНД ХЭЗЭЭ ХӨРӨНГӨ ОРУУЛАХ ВЭ?

ТОП-20 индексийн хэлбэлзэл (2015-2025)

	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025	ДУНДАЖ
1 сар	-2.10%	-1.00%	5.40%	-4.20%	7.50%	0.90%	10.50%	1.90%	3.50%	7.00%	2.90%	2.90%
2 сар	-3.50%	-3.00%	-0.90%	-0.10%	-0.60%	-0.90%	29.20%	-4.60%	2.40%	5.50%	1.70%	2.30%
3 сар	-3.50%	-5.10%	4.60%	-1.00%	-2.60%	-4.00%	31.20%	-6.10%	0.50%	1.90%		1.60%
4 сар	-3.00%	-1.50%	2.50%	-4.60%	-3.70%	-8.70%	4.10%	-0.90%	-5.20%	-3.30%		-2.40%
5 сар	-2.40%	-1.20%	-1.60%	-2.00%	0.30%	-2.10%	1.20%	-6.70%	0.50%	-0.40%		-1.40%
6 сар	13.90%	5.20%	-1.60%	0.90%	-1.80%	-1.00%	-7.70%	-3.70%	-0.60%	0.80%		0.50%
7 сар	-2.60%	10.80%	8.20%	-1.00%	3.60%	2.00%	-1.10%	-0.80%	1.10%	9.80%		3.00%
8 сар	-6.70%	-1.80%	8.70%	-0.90%	-2.80%	1.60%	7.70%	4.60%	0.00%	3.50%		1.40%
9 сар	-0.40%	-7.40%	16.60%	3.50%	-3.20%	2.70%	27.50%	-1.50%	-5.40%	-1.30%		3.10%
10 сар	-0.60%	-2.70%	16.90%	2.10%	-3.60%	1.60%	-10.00%	-1.90%	0.60%	0.20%		0.30%
11 сар	-2.90%	-3.40%	9.30%	-2.00%	0.00%	0.50%	-2.40%	1.10%	4.60%	1.80%		0.70%
12 сар	-3.60%	7.00%	0.10%	0.10%	1.90%	3.30%	5.80%	5.40%	5.00%	2.00%		2.70%

ТОП-20 индексийн сарын дундаж хэлбэлзэл (2015-2025)



Монголын ТОП-20 индексийн дундаж хэлбэлзлээс харахад 1-3 сар, 7-9 сар, 12 саруудад өсөлт давамгайлдаг байна.

Ямар стратеги баримтлах вэ?

- Ногдол ашиг хүртэхийг зорьж буй бол 1-3 сард хувьцаа худалдаж авах нь тохиромжтой.
- Хямд үнээр хувьцаа авах боломж хайж байгаа бол 4-5 сард зах зээлийн уналтыг ашиглах хэрэгтэй.
- 7-9 сард зах зээл өсөх магадлалтай тул эрт худалдан авч, өсөлтийг ашиглах боломжтой.
- Жилийн эцэст (12-р сар) дунд хугацааны өсөлт ажиглагдах хандлагатай тул урт хугацааны хөрөнгө оруулалтад тохиромжтой үе.